

Article

Inheritance and human rights

*Narantsetseg Munkhjargal**

Department of Private Law, School of Law, Otgontenger University, Ulaanbaatar, Mongolia

**Corresponding author: m.narantsetseg@otgontenger.edu.mn*

 <https://orcid.org/0009-0003-8299-2436>

Received: 28 March 2026. Accepted: 25 May 2026. Published online: 15 June 2026

Abstract

Inheritance is an integral part of the fundamental constitutional principles safeguarding an individual's right to property and serves as a primary source for the emergence of private ownership. Globally, inheritance relations have evolved with unique legal frameworks influenced by the socio-economic, cultural, and religious characteristics of each nation. While the Civil Code of Mongolia classifies inheritance into two forms—intestate (by law) and testamentary (by will)—certain ambiguities and regulatory gaps persist in practice. These include challenges in determining the inheritance rights of stepchildren, the methodology for identifying individual shares when bequeathing community property, and complexities surrounding the transfer of shares and intangible assets.

This article explores the legal nature of inheritance and conducts a comparative study of international legal trends, specifically between the Anglo-Saxon (Common Law) and Continental (Civil Law) systems, using comparative and analytical legal methodologies. By analyzing the challenges faced in Mongolian judicial practice and notarial acts, the study puts forward specific proposals and recommendations to refine legal regulations and further guarantee citizens' constitutional right to property.

Keywords: Inheritance, Will/Testament, Intestate succession, Mandatory share, Stepchild, Community property, Decedent (Testator), Heir (Beneficiary), Notarial act, Right to property, Shares, Trust fund.



© 2026, Author(s). CC BY-NC 4.0. This license enables reusers to distribute, remix, adapt, and build upon the material in any medium or format for noncommercial purposes only, and only so long as attribution is given to the creator. <https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

Өв залгамжлал ба хүний эрх

Мөнхжаргалын Наранцэцэг

Хувийн эрх зүйн тэнхим, Хууль зүйн сургууль, Отгонтэнгэр их сургууль, Улаанбаатар хот, Монгол Улс

Хураангуй

Өв залгамжлалын нь иргэний өмчлөх эрхийг баталгаажуулсан Үндсэн хуулийн суурь зарчмын салшгүй хэсэг бөгөөд хүний хувийн өмч үүсэх язгуур эх сурвалжийн нэг хэлбэр юм. Дэлхий даяар өв залгамжлалын харилцаа нь тухайн улс орны нийгэм, эдийн засаг, соёл, шашны онцлогоос хамааран өвөрмөц зохицуулалттай хөгжиж ирсэн. Монгол Улсын Иргэний хуульд өв залгамжлалыг хууль ёсоор болон гэрээслэлээр гэсэн хоёр хэлбэрт хуваадаг боловч практик дээр дагавар хүүхдийн өвлөх эрх, дундын өмчлөлийн хөрөнгийг гэрээслэхэд ногдох хэсгийг тодорхойлох аргачлал, хувьцаа болон биет бус хөрөнгийн шилжүүлэг зэрэгт тодорхой бус байдал, зохицуулалтын дутмаг талууд ажиглагдаж байна. Энэхүү өгүүлэлд өв залгамжлалын эрх зүйн мөн чанар, олон улсын (Англо-Саксон болон Эх газрын) эрх зүйн чиг хандлагыг харьцуулсан болон эрх зүйн аналитик арга зүйг ашиглан судалсан болно. Монгол Улсын Иргэний хуульд өв залгамжлалын харилцааг зохицуулсан ч шүүхийн практик болон нотариатын үйлдэл дээр дагавар хүүхдийн өвлөх эрх, дундын өмчлөлийн хөрөнгийг гэрээслэхэд ногдох хэсгийг тодорхойлох аргачлал, хувьцаа шилжүүлэх зэрэгт хийдэл гарсаар байна. Иймд эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилгоор хууль хэрэглээний практикт дүн шинжилгээ хийж, иргэний өмчлөх эрхийн баталгааг хангах эрх зүйн зохицуулалтын боловсронгуй болгох тодорхой саналыг дэвшүүллээ.

Түлхүүр үг: Өв залгамжлал, Гэрээслэл, Хууль ёсоор өвлөх, Заавал өвлөх хувь, Дагавар хүүхэд, Дундын өмч, Өвлүүлэгч, Өвлөгч, Нотариатын үйлдэл, Өмчлөх эрх, Хувьцаа, Итгэмжлэлийн сан.

Оршил

Монгол Улсын Үндсэн хуульд “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй . . .” /ҮХ-ийн 16.3/. Энэхүү зохицуулалтын агуулга нь иргэн эд хөрөнгийг өв залгамжлалаар авах болон шилжүүлэх эрхтэй бөгөөд хууль буюу гэрээгээр тохиролцсон олон арга замаар өөртөө эд хөрөнгөтэй болж, түүнийгээ өмчлөх туйлын эрхтэй бөгөөд энэ нь хүний эрхийн утгаараа бол жам ёсны эрх гэж ном зохиолд тэмдэглэсэн нь бий.

Аливаа улс гүрэн, овог, аймаг, үндэстний бүрэлдэн тогтсон түүхэн хөгжлийн явцад эрт үеэс уламжилж ирсэн бөгөөд хүний хувийн өмч үүсэх язгуур эх сурвалжийн нэг хэлбэр нь өв залгамжлал юм. Өв залгамжлал нь ямар ч улс үндэстэнд байх нийтлэг нэгэн дүр төрх, чиг

хандлагатайн зэрэгцээ тодорхой улс орны нийгэм, эдийн засаг, оюун санаа, шашин, зан заншлаас хамаарч өвөрмөц өөрийн онцлогтой байна (Мөнхжаргал, 2009). Тухайлбал англи-саксон буюу common law системтэй улс орнуудын хувьд өв хөрөнгөө өөрийн хүссэнээрээ удирдах боломжтой байдаг бөгөөд АНУ-ын цөөнгүй зарим мужид эхнэр болон нөхөрт нь тодорхой хэсэг оногдох байдлаар зохицуулсан байдаг (Littorno Law Group, 2024).

Ром-германы буюу civil law системтэй улс орнуудын хувьд хуулиар тогтоосон албадмал хувь буюу forced heirship хүчин төгөлдөр байдаг. Энэ нь тодорхой бүлгийн хүмүүст (гол төлөв үр хүүхэд, эхнэр/нөхөр) өвийн тодорхой хувийг заавал авах эрхийг олгодог. МУ-ын иргэний хуулийн 522.3. Гэрээслэгч бүх эд хөрөнгөө хууль ёсны өмчлөгч бус этгээдэд гэрээслэх тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр /эхнэр/, төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өвлөгчдөд хуульд зааснаар өвлүүлбэл зохих хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлнэ.

Ийнхүү заавал өвлүүлэх хэсгийн хэмжээг тодорхойлохдоо хуваарьт болон дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн өвлүүлэгчид оногдох хэсгийг оролцуулан тооцно гэсэн нь гэрээслэлээр эд хөрөнгөө өөр этгээдэд шилжүүлсэн нь хууль ёсны эхнэр, нөхөр, үр хүүхдүүдэд заавал тодорхой хэсгийг өгнө гэсэн агуулга харагдаж байна. Шашин-соёлын уламжлалт системтэй улс орнуудын хувьд өвлөх хувь нь Кораны заалтаар нарийн тогтоогдсон бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүст өвлөх хувь ялгаатай байдаг (Littorno Law Group, 2024).

Бидний амьдралд өв залгамжлалтай холбоотой олон асуудал байдаг бөгөөд түүний дундаас гэрээслэлтэй холбоотой маргаан цөөнгүй байна. Энэхүү маргаан нь эцсийн дүндээ ҮХ-ийн 16.13-д заасан хүний өмчлөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдож байдаг. Иймээс энэхүү эрхийг хангахын тулд өв залгамжлал тэр дундаа гэрээслэлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь чухал ач холбогдолтой байна. Иймд Өв залгамжлалын эрх зүйн харилцааны өнөөгийн байдал, дотоодын болон гадаадын судлагдсан байдалд үндэслэн практикт тулгамдаж буй асуудлуудыг илрүүлэх нь энэхүү судалгааны үндсэн зорилго болно. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

- Дагавар хүүхдийн өв залгамжлалын эрхийн асуудлаар шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх
- Хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс өвлүүлэгчид ногдох хэсгийг тодорхойлох үеийн хүндрэлийг нотариатын үйлдэл болон шүүхийн практикт тулгуурлан тодорхойлох
- Дээрх асуудлуудыг шийдвэрлэх эрх зүйн гарц шийдлийг тодорхойлох

Өв залгамжлал ба гэрээслэлийн тухай ойлголт

Өв залгамжлал гэдэг нь аливаа хүн насан эцэс болсон тохиолдолд түүний мэдлийн эд хөрөнгө өөр субъектэд шилжих тухай ухагдахуун юм (Боловсон, 2018). Өв залгамжлалын эрх зүй нь нийгмийн тодорхой төрлийн харилцаа буюу өвлүүлэгч, өвлөгчийн хоорондын эд хөрөнгөтэй холбоотой үүссэн харилцааг зохицуулна. Энэ утгаараа Иргэний эрх зүйн зохицуулах зүйлийн салшгүй нэг хэсэг болно (Мөнхжаргал, 2009).

Өв залгамжлал нь иргэн нас барсантай холбоотой үүсдэг харилцаа бөгөөд амьд байгаа иргэнтэй холбоотой өвийг залгамжлуулах гэсэн ухагдахуун байж болохгүй юм. Харин нас барсны дараа түүний өв хөрөнгийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид зохих журмын дагуу хүлээн авна.

Онолын талаас нь өв залгамжлалыг:

- Хууль ёсоор өв залгамжлал
- Гэрээслэлээр өв залгамжлал

Хууль ёсоор үүсэх өв залгамжлалын харилцаа нь өв залгамжлалын харилцааны хувьд хамгийн нийтлэг байдаг өргөн хүрээний зохицуулалт юм. Учир нь иргэн гэрээслэл үлдээгээгүй нас барсантай холбоотой энэхүү харилцаа үүсэх бөгөөд өв залгамжлагчид нь үндсэн хуульд заасан эрхийнхээ хүрээнд өвийг залгамжлан авах эрхтэй.

Өв залгамжлагч субъект: Хуульд дараах субъектүүдийг өв залгамжлагчид оруулсан байдаг, үүнд:

- Нас барагчтай ясан болон цусан төрлийн холбоотой субъектүүд.
- Өвлүүлэгч нас барах хүртлээ 1-ээс доошгүй жилийн хугацаанд хамт амьдарч байсан хөдөлмөрийн чадваргүй иргэн байж болно (ИХ-520.3). Энэ нь өвлүүлэгчтэй ясан болон цусан төрлийн хамааралгүй хүн эд хөрөнгийг өвлөн авч болно.

Иргэний хуулийн 520-р зүйлд өв залгамжлан авах эрхтэй субъектүүдийг хуульчилсан бөгөөд хүүхдийн, тэр дундаа дагавар хүүхдийн өв залгамжлах эрхийн талаарх зохицуулалт дутмаг байгаа нь дагавар хүүхдийн өвлөх эрх зөрчигдөхөд хүргэж байна. “Шүүх нь дагавар хүүхдийн харилцааны бодит нөхцөл байдлыг шалгалгүй, зөвхөн Иргэний хуулийн заалтыг механикаар хэрэглэн өвлөх эрхгүй гэж шийддэг” гэж тодорхой дурдсан (Тайван, 2019).

Монгол Улсын шүүхийн практикт дагавар хүүхдийг өөрийн овгоор овоглосон тохиолдлыг Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1.1-д заасан өвлөх эрх бүхий субъектэд тооцон шийдвэрлэж байна. Үүний нэг жишээ нь Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны

шүүхийн 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 101/ШШ2022/02476 дугаар шийдвэр, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 101/ШШ2021/01854 дугаар шийдвэр юм. Уг шийдвэрээр талийгаач нь хүүхдийг өөрийн овгоор овоглож байсан нь түүнийг өөрийн хүүхэд гэж хүлээн зөвшөөрсөн хүсэл зоригийн илэрхийлэл гэж дүгнэн, дагавар хүүхдийг хууль ёсны өвлөгчөөр тогтоожээ. Үүнээс бусдаар уг хүүхдийн өв залгамжлан авах эрх зөрчигдсөн хэвээр байна.

Гадаад улсуудын эрх зүйн зохицуулалтаас харвал дагавар хүүхэд хууль ёсны хүүхэд шиг өвийг залгамжлах эрх байхгүй байгаа нь монгол улсад төдийгүй бусад улсад ч энэ хүүхдийн эрх зөрчигдсөөр байна. Иймээс иргэний 520-р зүйлийн хуулийн хэрэглээнд шүүхийн тайлбар гаргах шаардлагатай харагдаж байна.

Өвлөгдөх эд хөрөнгө: Өвлөгдөх эд хөрөнгө нь хуваарьт болон хамтран өмчлөх дундын хөрөнгөөс хамааран хэрхэн хуваарилагдах эсэх нь тодорхойлогддог. Өвлөгдөх эд хөрөнгө хуваарьт эд хөрөнгө байгаа бол өвийг залгамжлан авагч нарт тэнцүү хуваан ногдуулдаг. Харин хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн хувьд өв залгамжлуулагчид ногдох хэсгийг тодорхойлсны дараа зөвхөн тэр хэсэг нь өв залгамжлагч нарт хуваарилагдана.

Жишээ нь: Амар, Цолмон 2 гэр бүлээ батлуулан 10 жил хамт амьдарсан бөгөөд 2 хүүхэдтэй болж 200 саяар үнэлэгдэх үл хөдлөх дундын хөрөнгөтэй болсон. Эхнэр нь өвчний улмаас нас барж өв залгамжлалын харилцаа үүссэн. Энэ тохиолдолд 200 саяар үнэлэгдэх дундын эд хөрөнгийн эхнэрт ногдох хэсгийг тодорхойлж, тодорхойлогдсон хэсэг нь бусад 3 гишүүдэд өв залгамжлагдана. Нөхцөлөөс харвал эхнэрт 50 сая төгрөг ногдож байгаа бөгөөд энэхүү хэсэг нь 3 хүнд хуваагдах замаар өвийн асуудлыг шийдвэрлэнэ. Ногдох хэсгийг нь тодорхойлохгүйгээр өвийг шилжүүлсэн тохиолдолд бусад 3 гишүүний өмчлөх эрх зөрчигдөнө. Шүүхийн практикаас харвал дундын эд хөрөнгийг 129.1.4-д заасны дагуу маргааныг шийдвэрлэж байгаа нь өвлөгчдийн өмчлөх эрх зөрчигдөх нь харьцангуй бага байна. Харин практикт Хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн өвлүүлэгчид ногдох хэсгийг тодорхойлохгүйгээр өв залгамжлалын асуудлыг бусад өмчлөгчдийн эрхийг зөрчих эрсдэлтэй байна. Иймээс Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 171 дүгээр тушаалын хавсралт “ Нотариатын үйлдэл хийх заавар ” -ын 8-р зүйл дэх “ Өвлөх эрхийн гэрчилгээ олгох ” хэсэгт нэмэлт оруулах шаардлагатай байна. Ингэснээр нотариатчид нэгдсэн нэг стандартаар дундын өмчийн өвийг шийдвэрлэх ба өвлөгчдийн дунд маргаан гарах, бусад гишүүдийн өмчлөх эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой болох юм.

Монгол Улсын шүүхийн практикт хувьцааг эд хөрөнгийн эрх гэж үздэг тул Иргэний хуулийн дагуу өв залгамжлагдана. Хувьцаа өв залгамжлагдах нь бусад объектоор харьцуулбал

онцлогтой төдийгүй хүндрэлтэй байдаг. Тухайлбал иргэний хуульд хувьцааны өв залгамжлалын талаарх нарийн зохицуулалт байхгүй. ҮЦТХТ-ийн үйлчилгээний хураамж өндөр, өвлөгчдөд санхүүгийн дарамт үүсгэдэг, хувьцааны шилжүүлэлтийн бүртгэл олон шат дамжлагатай, компани ялангуяа ХХК-ийн хувьцаа эзэмшигчид нь өв залгамжлагчдыг өөрийн компанидаа оруулах сонирхол бага байгаа зэрэг нь өв залгамжлагч субъектийн өмчлөх эрх зөрчигдөх магадлалтай байна.

Гэрээслэлээр үүсэх өв залгамжлалын харилцаа

Өв залгамжлалын нэг төрөл нь гэрээслэл байдаг. “Гэрээслэл нь өвлүүлэгч амьд сэрүүн байхдаа өөрийн хөрөнгө, эрхийг үхсэний дараа хэрхэн шилжүүлэх талаар хүсэл зориг илэрхийлсэн баримт бичиг юм. Өв залгамжлалын үндсэн хэлбэрүүдийн нэг бөгөөд Иргэний хуулиар тогтоосон хэлбэр, журмын дагуу үйлдэгдэх ёстой” (Мөнхжаргал, 2009).

“Гэрээслэл бол өвлүүлэгчийн нас барсны дараах хөрөнгийн шилжилтийг зохицуулах нэг талын хүсэл зоригийн илэрхийлэл мөн. Монголын Иргэний хуулийн хүрээнд гэрээслэл нь өвлүүлэгчийн үхсэний дараах хөрөнгийн хувь заяаг шийдвэрлэдэг эрх зүйн акт юм”.

“Иргэн нь хуульд зааснаар өвлөх эрхтэй буюу эрхгүй нэг буюу хэд хэдэн иргэн, түүнчлэн төр буюу хуулийн этгээдэд өөрийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь үзэмжээрээ хуваариалан гэрээсэлж болно” (ИХ-522.1).

Гэрээслэлээр үүсэх өв залгамжлалын харилцааны субъект:

- Хууль ёсны өв залгамжлагч
- Хууль ёсны бус өв залгамжлагч

Хууль ёсны өв залгамжлагчдыг иргэний хуулийн 520-р зүйлд заасан бөгөөд гэрээслэгч нь эдгээр хууль ёсны өв залгамжлагчдын хэн аль нэгэнд нь гэрээслэлээр өөрийн эд хөрөнгийг үлдээж байгаа нь үндсэн хуульд заасан өмчлөх эрхээ хэрэгжүүлж байгаагийн нэг илрэл гэж үзэж болох юм. Гэвч зөвхөн тухайчлан нэг этгээдэд (хууль ёсны бус) эд хөрөнгөө үлдээсэн ч гэсэн түүнийг нас барсны дараа хууль ёсны өв залгамжлагч нарт тодорхой нэг хөрөнгийг өгч байгаа нь түүний амьд ахуйдаа илэрхийлсэн хүсэл зориг зөрчигдөж байна гэж үзэж болох юм.

АНУ-ын зарим муж улсуудын хууль (жишээ нь: Uniform Probate Code)-д "Гэрээслэл үйлдэх бүрэн эрх чөлөө"-г чухалчилдаг. Өвлүүлэгч өөрийн хөрөнгөө хэнд ч (бүр амьтанд ч) үлдээж болно. Гэхдээ ихэнх мужид эхнэр/нөхрийг нь өвөөс бүрэн хасахыг зөвшөөрдөггүй зохицуулалт байгаа нь гэрээслэгчийн хүсэл сонирхлыг илүү харгалзаж байна.

Харин Германы Иргэний хуулийн 2303 дугаар зүйлд "Pflichtteil" буюу заавал өвлөх эрхийг нарийвчлан заасан байдаг. Гэрээслэгч хэнийг ч өв залгамжлагчаар томилсон бай, түүний ойр дотнын хүмүүс (хүүхэд, эхнэр/нөхөр) хуулиар тогтоосон хувь хэмжээг заавал хүртэх эрхтэй. Энэ агуулга бүхий зохицуулалт нь манай монгол улсын иргэний хуулийн 522.3-аас харж болох юм.

Мөн түүнчлэн хүүхдийн эрх, цаашлаад өв залгамжлах эрхийг илүү хангаж өгсөн зохицуулалт нь Францын Иргэний хууль (Code Civil) юм. Онцлог нь: Хүүхдийн эрхийг дээд зэргээр хамгаалдаг. Өвлүүлэгч хөрөнгийнхөө зөвхөн тодорхой хэсгийг л гэрээслэлээр бусдад өгөх эрхтэй бөгөөд үлдсэн хэсэг нь заавал хүүхдүүдэд нь очих ёстой гэж зааж өгсөн байдаг. Энэ мэтчилэн улс орнууд нь хэний эрхийг голлон авч үзэж вэ гэдгээс хамааран хэнд өв хөрөнгийг өвлүүлэх вэ гэсэн зохицуулалтыг хийдэг байна.

МУ-ын хуульд гэрээслэгч хууль ёсны бус этгээдэд бүх эд хөрөнгөө гэрээслэлээр үлдээсэн бол:

- Өвлүүлэгчийн насанд хүрээгүй болон хөдөлмөрийн чадваргүй хүүхэд, нас барсны хойно төрсөн хүүхэд.
- Түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр /эхнэр/, төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх.
- Хууль ёсны бусад өвлөгчид.

Эдгээр субъектүүдэд өв $\frac{1}{2}$ -ээс багагүй хэсгийг заавал өвлүүлнэ гэсэн нь өвлөгч субъектүүдийг их өргөнөөр тодорхойлсон байна. Хууль ёсны бус өв залгамжлагчид нь гэрээслэгчтэй ясан болон цусан төрлийн ямар нэг холбоотой бус иргэн байж болохоос гадна хуулийн этгээд (ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, сүм хийд, шашны байгууллага, сургууль эмнэлэг, асрамжийн газар, орон нутаг) байж болно.

Өвлөгч субъектүүдийг ийм өргөн агуулгаар зохицуулснаас гадна амьтанд эд хөрөнгөө гэрээслэн үлдээх зохицуулалттай улс орнууд байна.

- АНУ, Их Британи зэрэг Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад Өвлүүлэгч амьтандаа зориулж "Итгэмжлэлийн сан" байгуулаад тэр сангаараа дамжуулан амьтны хоол хүнс болон асрах үйл ажиллагаанд зарцуулагдана.
- Эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудад Өвлүүлэгч өөрийн найз эсвэл төрөл төрөгсдөдөө эд хөрөнгөө үлдээхдээ "Миний муурыг үхэх хүртэл нь асарч хамгаалж, сард тэдэн төгрөгийн хоол авч өгөх" гэсэн нөхцөл тавьдаг. Хэрэв нөхцөл биелүүлэхгүй

бол бусад өв залгамжлагчид эсвэл шүүх тухайн хүний өвлөх эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авах боломжтой.

Энэхүү зохицуулалтын агуулга нь Монгол улсын Иргэний хуулийн 526-р зүйлд тусгалаа олсон гэж үзэж болох бөгөөд амьтанд эд хөрөнгөө үлдээх зохицуулалт нь нээлттэй байж болох юм.

Өвлөгдөх эд хөрөнгө: Гэрээслэлээр өөрийн эд хөрөнгөө үлдээхийн тулд хуульд зааснаар нотариатаар заавал гэрчлүүлж байж хүчин төгөлдөр болно. Гэрээслэгдэх эд хөрөнгө:

- Хуваарьт эд хөрөнгө
- Хамтран өмчлөх дундын эд хөрөнгө

Эдгээр эд хөрөнгийг гэрээслэлээр үлдээх нь мөн онцлогтой. Гэрээслэгч нь өөрийн хуваарьт эд хөрөнгийг гэрээслэлээр үлдээхдээ тухайн хүний хуваарьт хөрөнгө гэдэг нь нотлогдож байвал нотариат нь гэрээслэлийг гэрчилнэ. Харин хамтран өмчлөх дундын хөрөнгө байгаа тохиолдолд тэр эд хөрөнгийг гэрээслэлээр үлдээхэд анхаарах шаардлагатай. Учир нь гэрээслэлээр үлдээх эд хөрөнгө нь дундын хөрөнгө бол тэр нь нотлогдож байвал гэрээслэгч өөрт ногдох хэсгийг л гэрээслэлээр үлдээх эрхтэй.

Энэ тохиолдолд гэрээслэгчид ногдох хувийг хэрхэн тодорхойлох, түүнийг хэрхэн нотлох вэ гэдэг нь илүү ач холбогдолтой юм. Хамтран өмчлөх дундын эд хөрөнгө (жишээ нь: гэр бүлийн гишүүдийн дундын орон сууц) нь нэг хүний өмч биш, хэд хэдэн хүний өмч байдаг тул гэрээслэл үйлдэхэд дараах зохицуулалт үйлчилнэ. Өөрт ногдох хэсгийг тодорхойлох:

- Өвлүүлэгч нь хамтран өмчлөх дундын хөрөнгийг бүхэлд нь биш, зөвхөн өөрт ногдох хэсгээ гэрээслэх эрхтэй.
- Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ дээр хувийг тодорхойлсон бол түүгээр өөрт ногдох хэсгээ гэрээслэлээр үлдээх.
- Үл хөдлөх эрхийн гэрчилгээ дээр энэ талаар тодорхойлоогүй бол (ИХ-129.2) хуулиараа бүх өмчлөгчид адил хэмжээний хувь эзэмшдэг тул дундын эд хөрөнгийн 50 хувийг гэрээслэлээр үлдээнэ.

Гэхдээ ИХ-ийн 129.4 “Энэ хуулийн 129.3-т зааснаас бусад гэр бүлийн гишүүнд ногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө бий болгоход оруулсан түүний хөдөлмөрийн оролцоо, хөрөнгийн хэмжээг харгалзан багасгах, эсхүл олгохгүй байхаар шүүх шийдвэрлэж болно”. Практикаас харахад тухайн этгээд хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн өөрт ногдох хэсгээ гэрээслэлээр үлдээх тохиолдолд нотариатч нь адил тэнцүү байдлаар гэрээслэгдэх хөрөнгийг гэрчилж байгаа нь ИХ-ийн 129.4-ийн дагуу

гэрээслэл үлдээгч нь их эсхүл бага хувийн аль нь ч ногдох магадлалтай тул өвлөгч эсхүл өвлүүлэгч субъектийн өмчлөх эрх зөрчигдөх магадлалтай байгаа тул эрх зүйн зохицуулалтыг (нотариатын хууль, нотариатын үйлдэл эрхлэн хийх заавар) илүү сайжруулах шаардлага тавигдаж байна.

Гадаадын бусад улсад тухайлбал АНУ (Аризона, Калифорни, Техас)-ын зарим мужид дундын хөрөнгө байгаа тохиолдолд 50/50 хувиар өмчилдөг бөгөөд энэ хэсгээ л гэрээслэн үлдээх эрхтэй (California Family Code § 760). Герман улсын Иргэний хуулийн агуулга нь дундын эд хөрөнгө нь гэр бүлийн гишүүдэд адил байхаар зохицуулсан бөгөөд үүнд хуваарьт эд хөрөнгө нийлсэн, холилдсон бол хэрхэн ногдох хэсгийг гаргах вэ гэдгээр тооцоолол хийж гаргана. Үүнийг нотариатч хийнэ.

Дүгнэлт ба Санал

Өв залгамжлалын эрх зүйн зохицуулалт нь иргэний өмчлөх эрхийг баталгаажуулдаг Үндсэн хуулийн суурь зарчмын салшгүй хэсэг бөгөөд судалгаанаас үзэхэд дараах үндсэн дүгнэлтүүдэд хүрч байна.

Гэрээслэгчийн хүсэл зориг ба хуулийн хязгаарлалт: Гэрээслэл нь иргэний өөрийн өмчөө үзэмжээрээ захиран зарцуулах "жам ёсны эрх"-ийн илрэл боловч Монгол Улс болон Эх газрын эрх зүйн системтэй орнуудад (Герман, Франц) энэхүү эрх чөлөөг "Заавал өвлөх эрх"-ээр хязгаарладаг. Энэ нь өвлүүлэгчийн гэр бүлийн хамаарал бүхий хөдөлмөрийн чадваргүй, насанд хүрээгүй гишүүдийн нийгмийн баталгааг хангах зорилготой боловч нөгөө талдаа гэрээслэгчийн жинхэнэ хүсэл зоригийг бүрэн хэрэгжүүлэхэд саад болдог "хоёрдмол" шинжтэй байна.

Хамтран өмчлөх дундын хөрөнгийн асуудал: Дундын өмчийг гэрээслэх тохиолдолд гэрээслэгчид ногдох хэсгийг тодорхойлох нь практик дээр хамгийн хүндрэлтэй байна. Монгол Улсын Иргэний хуулийн 129.4-т заасан хөдөлмөрийн оролцоог харгалзан хувь хэмжээг өөрчлөх боломжийг нотариатын үйлдэлд нарийвчлан тусгаагүйгээс иргэдийн өмчлөх эрх зөрчигдөх эрсдэлтэй байна. Герман улсын туршлага шиг "хөрөнгийн өсөлтийг тооцох" нарийн аргачлалыг нотариатын үйлдэл болон шүүхийн практикт нэвтрүүлэх замаар энэ асуудлыг боловсронгуй болгох шаардлагатай.

Өв залгамжлагч субъектийн эрхийн хамгаалалт: Судалгаанаас үзэхэд дагавар хүүхдийн өвлөх эрхийн зохицуулалт Монгол Улсад төдийгүй олон улсад дутмаг байгаа нь анхаарал татаж байна. Шүүх зөвхөн овгоор нь ялгаварлах буюу хуулийг механикаар хэрэглэх бус, бодит

амьдрал дээрх гэр бүлийн харилцааг үндэслэн дагавар хүүхдийн эрхийг хамгаалсан шүүхийн тайлбарыг гаргах нь зүйтэй.

Шинэ төрлийн өвлөгдөх объект ба түүний зохицуулалт: Хувьцаа, үнэт цаас зэрэг биет бус хөрөнгийн өв залгамжлал нь бүртгэлийн олон шат дамжлага, санхүүгийн өндөр зардалтай байгаа нь иргэдийн өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд саад болж байна. Мөн амьтанд эд хөрөнгө үлдээх олон улсын "итгэмжлэлийн сан"-гийн туршлагыг Иргэний хуулийн 526 дугаар зүйлтэй (Гэрээслэлээр үүрэг хүлээлгэх) уялдуулан хэрэглэх боломж Монгол Улсад нээлттэй байгааг онцлох хэрэгтэй.

Өв залгамжлалын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохын тулд:

- Нотариатын үйлдэл эрхлэх зааварт дундын өмчийн ногдох хэсгийг тогтоох аргачлалыг нарийвчлах. Тухайлбал Нотариатын үйлдэл эрхлэн хийх зааврын 8-р зүйлийн өвлөх эрхийн гэрчилгээ олгох гэсэн нотариатын үйлдэлд “Хэрэв өвлөгдөх эд хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч байвал нотариатч нь Иргэний хуулийн 129-р зүйлд заасны дагуу эхлээд өвлүүлэгчид ногдох хэсгийг гэр бүлийн гишүүдийн тоонд тэнцүү хуваах зарчмаар тооцон тусгаарласны үндсэн дээр зөвхөн тухайн ногдох хэсэгт өвлөх эрхийн гэрчилгээ олгоно” гэж нэмэлт оруулах
- Хувьцаа өвлөх процессыг хялбарчлах, зардлыг бууруулах.
- Дагавар хүүхэд болон гэрлэлтээ бүртгүүлээгүй хамтран амьдрагчдын өвлөх эрхийн талаар Дээд шүүхийн албан ёсны тайлбар гаргах зэрэг нь иргэдийн өмчлөх эрхийн баталгааг хангахад чухал ач холбогдолтой юм.

Өв залгамжлал нь зөвхөн эд хөрөнгө шилжүүлэх техник ажиллагаа бус, хүний өмчлөх эрхийн үргэлжлэл тул гэрээслэгчийн хүсэл зоригийг дээдлэх болон гэр бүлийн гишүүдийн эрх ашгийг хамгаалах гэсэн хоёр этгээдийн эрх зүйн зохицуулалтыг шинэчлэлээр тогтоох шаардлагатай байна.

Ашигласан эх сурвалж

Bürgerliches Gesetzbuch [BGB] [Civil Code]. (Germany).

California Family Code, Section 760. (1992).

Code civil [Civil Code]. (France).

Legaldata.mn. (2026). *Хууль зүйн нэгдсэн мэдээллийн сан*. Retrieved from <https://www.legaldata.mn>

Littorno Law Group. (2024). *Global perspectives on inheritance law: Common law vs. civil law systems*. Retrieved from <https://www.littornolaw.com>

Uniform Probate Code [UPC]. (United States).

Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх. (2021). *Шүүхийн шийдвэр №101/ШШ2021/01854*. Retrieved from <https://www.shuukh.mn>

Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх. (2022). *Шүүхийн шийдвэр №101/ШШ2022/02476*. Retrieved from <https://www.shuukh.mn>

Боловсон, П. (2018). *Иргэний эрх зүй: Өв залгамжлал*. [Хэвлэлийн газар].

Монгол Улсын Иргэний хууль. (2002). *Төрийн мэдээлэл*, №7.

Монгол Улсын Үндсэн хууль. (1992). *Төрийн мэдээлэл*, №1.

Монголын Нотариатын Танхим. (2026). *Нотариатын үйлдэл эрхлэн гүйцэтгэх заавар*. Retrieved from <https://www.notary.mn>

Мөнхжаргал, Т. (2009). *Өв залгамжлалын эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал*. [Хэвлэлийн газар].

Тайван, Г. (2019). Дагавар хүүхдийн өв залгамжлах эрхийн хэрэгжилт ба шүүхийн практик. *Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл*, [Боть/дугаар], [Хуудасны дугаар].

Улаанбаатар, Б. (2012). *Монгол Улсын иргэний эрх зүй: Өв залгамжлал*. [Хэвлэлийн газар].

Улаанбаатар, Б. нар. (2018). *Иргэний эрх зүй (Ерөнхий ба тусгай анги)*. [Хэвлэлийн газар].